

**Хуулийн бичвэр дэх дан нэр томьёоны
бүтцийн судалгаа**

Түвдэндоржийн БАТБЯМБА*

Монгол Улс, Улаанбаатар, Шинжлэх Ухааны Академийн

Хэл зохиолын хүрээлэнгийн

Компьютер хэл шинжлэлийн лаборатори

Received: May 14, 2025 | **Accepted:** September 10, 2025 | **Published:** October 15, 2025

Хураангуй: Бид ШУА-ийн ХЗХ-ийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбарын “Хуулийн хэлний үгийн сан, хэл зүйн судалгаа” сэдэвт төсөлт ажлын хүрээнд Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа 449 хуулийн 1,696,931 үгтэй цахим санг байгуулав. Улмаар уг сандаа тулгуурлан хуулийн бичвэр дэх дан нэр томьёог бүтцийн талаас судалсан судалгааны зарим үр дүнгээ танилцуулахыг зорьсон болно.

Бид судалгаандаа эх хэлний боловсруулалтад өргөн хэрэглэдэг үгсийг материалын санд бүртгэх үндсэн аргад түшиглэж, “Онцлогийг тодорхойлох арга” (Attribute Description Method)-аар материалын сандаа тэмдэг хадсан бөгөөд цахим сангийн боловсруулалтаа “Монгол хэл боловсруулалтын үзүүлэн хуудас (лаборатори, 2016)”-ыг гараар тэмдэглэгээ хийх аргатай хослуулсан. Түүнчлэн үгсийн сангийн хэрэглээний чанарыг үнэлэх, үгийн бүтэц, хэрэглээн дэх давтамжийг тогтооход AntConc болон EXCEL программын хэрэгслүүдийг ашигласнаас гадна нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, тайлбарлан бичих зэрэг олон аргыг түлхүү ашиглав.

Түүвэрлэн авсан 1399 хуулийн нэр томьёог бүтэх аргаар ангилж үзэхэд, дан бүтэцтэй нэр томьёо 219, нийлмэл бүтэцтэй нэр томьёо 1180 байна. Монгол хэлний үг бүтэх аргаар ангилж үзвэл, үүсмэл нэр томьёо 140, үүсмэл биш нэр томьёо 79 бүртгэгдэв. Энэхүү хуулийн дан нэр томьёоны бүтцийн судалгаа нь

* © Т.Батбямба, 2025

Email: Batbyamba9898@gmail.com



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

нэр томъёо товч тодорхой, салаа утгагүй бөгөөд оновчтой байхаас гадна нэр томъёог бүтээж байгаа үгийн утга, ухагдахуун нь хоорондоо яв цав тохирч байх ёстой гэсэн нэр томъёоны үндсэн шаардлагад нийцэж буй эсэхийг тодорхойлоход ач холбогдолтой юм.

Монгол Улсын хувьд хуулийн хэл найруулгад ашиглаж буй дан нэр томъёоны бүтэц, бүтэх арга, хэрэглээний байдал, цаашилаад нэр томъёоны стандартыг бий болгоход шаардах эхний алхам нь уг төрлийн шинжилгээ болно.

Түлхүүр үг: цахим сан, давтамж, нэр томъёо бүтэх арга, үгийн аймаг, нэр томъёоны орчуулга,

Structural Analysis of Single-Terms in Legal Texts

BATBYAMBA Tuvdendorj

Department of Computer Linguistics,
Institute of Language and Literature, Mongolian Academy of Sciences,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: Within the framework of the project titled “Lexical and Grammatical Study of Legal Language” conducted by the Department of Applied Linguistics at the Institute of Language and Literature, Mongolian Academy of Sciences, we created an electronic database consisting of 1,696,931 words from 449 laws currently in force in Mongolia. Based on this database, we aimed to present some results of our structural analysis of single-term legal terminologies. In our research, we relied on the core methodology of registering frequently used words in native language processing. We employed the “Attribute Description Method” to tag the materials in the database and combined this with manual annotation methods based on the “Mongolian Language Processing Demonstration Page (Laboratory, 2016).” Additionally, we utilized tools from AntConc and Excel programs to assess the usability of the lexicon, analyze word structures, and determine frequency of usage. We also made extensive use of various analytical methods such as summarizing, dissecting, and interpretive writing. When classifying terminologies from 1,399 sampled laws based on their formation, 219 were found to be of simple structure, while 1,180 were compound terms. According to word-formation methods in the Mongolian language, 140 of the terms were derived (neologisms), and 79 were non-derived terms. This structural analysis of single-term legal terminologies is important in determining whether the terms meet core terminological criteria—being concise, unambiguous, and accurate—as well as ensuring that the meanings and concepts of the constituent words align precisely. For Mongolia, such analysis serves as a foundational step toward understanding the structure, formation methods, and usage patterns of single-

term terminologies in legal drafting, and ultimately contributes to the development of standardized legal terminology.

Keywords: *electronic database, frequency, term formation method, parts of speech, terminology translation*

1. Удиртгал

Хууль нь нийгмийн албан харилцааг зохицуулж байдаг баримт бичиг бөгөөд хэл шинжлэлийн үүднээс үзвэл төр ард түмэнтэйгээ харилцаж буй албан ёсны хэл юм. Энэ хэл хэдий чинээ ойлгомжтой, зөв шударга, цэвэр тунгалаг байна төдий чинээ төр ард түмний итгэлцэл гүнзгий, харилцаа сэвгүй байна гэсэн үг. Хуулийн хэл найруулга нь албан бичгийн бусад төрөлтэйгөө ерөнхийдөө адил боловч бас өөрийн гэсэн бичгийн өвөрмөц онцлогтой. Үүнд:

- Хууль нь товч бөгөөд тодорхой байх ёстой.
- Бусад хэл найруулгыг бодвол ерөнхийлөн дүгнэсэн шинжтэй байдаг.
- Тогтсон загвартай байдаг.
- Олон нийтэд ойлгомжтой байх ёстой ажээ.

Үгийн сангийн онцлогоос нь товч дурдвал,

- Нийт олны ярилцдаг хамгийн энгийн бөгөөд салаа утгагүй үгийг сонгож хэрэглэдэг. Жишээ нь, “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэх мэт.
- Хуулийг нийт олноороо заавал дагаж мөрдөх, дээдлэн хүндэтгэх ёстой байдаг учир түүний хэл найруулгад хүндэтгэлийн үг хэллэгийг өргөнөөр ашиглах нь бий. Жишээ нь, соёрхон батлах, цог хийморь, ариун цагаан өнгө, өргөн мэдүүлэх гэх мэт.

Найруулгад нэг үгийг олон дахин давтаж хэрэглэвэл найруулга сулруулах муу нөлөөтэй боловч хуульд тухайн салбартай холбоотой үг хэллэгийг олон дахин давтаж бичиж болдог. Жишээ нь, Монгол улсын хөдөлмөрийн тухай хуульд (Хурал, Монгол улсын хөдөлмөрийн тухай хууль, 2003) ажил олгогч, ажилтан, аж ахуйн нэгж байгууллага гэх мэт үгс олон дахин давтагдаж байна.

Хуулийн хэл найруулгад нутгийн аялгууны үг, хар ярианы үг, гадаад хэлний үгийг хэрэглэдэггүй. Хэрэглэвэл голдуу утга зохиолын хэм хэмжээнд тохирсон тухайн салбарт түгээмэл хэрэглэдэг нэр томъёог ашигладаг. Жишээ нь, прокурор, контракт, арбитр, машин механизм, техник, паспорт гэх мэт.

Олон нийтэд ойлгомжтой байх шаардлага тавьдаг тул хуучин үг, түүхэн үгийг бараг хэрэглэдэггүй, шинэ үгийг хэрэглэх шаардлагатай бол нэмэлт тайлбартайгаар хэрэглэдэг байна (Ц.Сүхбаатар, 2009).

Хуулийн хэл найруулгад салаа утгатай болон ижил утгатай үгийг хэрэглэдэггүй. Учир нь эдгээр нь найруулгыг бүрхэгдүүлэх юм уу хоёрдмол санаатай болгодог.

Хуулийн хэл найруулгад, бусдад итгэл үнэмшил төрүүлэх, уриалан дагуулах зорилгоор ойролцоо утгатай үгийг хоршин хэрэглэх нь цөөнгүй. Жишээ нь, “Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ” (Хурал, Монгол улсын үндсэн хууль, 2004) гэх мэт.

Манай улсын хувьд өнөөдрийн байдлаар 932 хууль, 2443 Монгол улсын их хурлын тогтоол, 3085 захиргааны хэм хэмжээний акт, 326 хуулийн орчуулга, 689 Монгол Улсын олон улсын гэрээ, 218 Ерөнхийлөгчийн зарлиг, 317 Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, 257 Улсын дээд шүүхийн тогтоол, багтаасан эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийг (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2025) нээлттэйгээр байршуулж, ашиглах, судалгаа хийх боломжийг хэн бүхэнд олгож байна.

Хууль зүйн судалгааны төв болон их дээд сургуулийн багш, судлаач, эрдэм шинжилгээний ажилтнууд хууль тогтоомжийн төсөл боловсруулахад чиглэсэн судалгаа, лавлагаа, мэдээлэл бэлтгэх, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх, хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, зардлыг тооцох, илтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл бэлтгэн хэвлүүлэх, эрдэм шинжилгээний хурал, семинар, хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг ажлыг амжилттай хийж, үр дүнд хүрсээр байна. Учир нь хуулийг боловсруулан батлах, мөн нэмэн өөрчлөх зэрэг бүхий л үйл ажиллагаанд шинжлэх ухааны ул суурьтай судалгаа хэрэгтэй болдог. Иймээс ч бид ШУА-ийн ХЗХ-ийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбарын “Хуулийн хэлний үгийн сан, хэл зүйн судалгаа” сэдэвт төсөлт ажлын хүрээнд Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа 449 хуулийн 1,696,931 үгээр хуулийн цахим санг байгуулж, тус сангийнхаа үгийн санд давтамжийн судалгаа хийж, хуулийн үгийн сан дахь дан нэр томьёог бүтцийн талаас судлах ажилд өөрсдийн саналыг нэмэрлэхийг зорив.

Өдгөө дэлхийн улс орон бүр өөр өөрийн хэлний, уран зохиолын, хуулийн, толь бичгийн, нэр томьёоны гэх зэрэг цахим санг байгуулан, хөгжүүлсээр байгаа өнөө үед тооцоо хэл шинжлэлийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн Монгол Улсын хуулийн цахим санд тулгуурласан судалгааг олон шинжлэх ухааны уулзварт хийх нь хуулийн нэр томьёог бүртгэн тооцоолох, нэр томьёоны стандартыг тогтоох, дагаж мөрдөх зэрэгт чухал бааз суурь болно.

Монгол Улсын хувьд хуулийн хэл найруулгад ашиглаж буй дан нэр томьёоны бүтэц, бүтэх арга, хэрэглээний байдал, цаашлаад нэр томьёоны стандартыг бий болгоход шаардах эхний алхам нь уг төрлийн шинжилгээ болно.

Энэхүү өгүүлэл нь 1. Удиртгал, 2. Судалгааны арга зүй, 3. Судалгааны хэсэг, 4. Дүгнэлтээс гадна ном зүй, хавсралт гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

2. Судалгааны арга зүй

Бид энд дан бүтэцтэй нэр томьёо бүтэх арга хийгээд үг бүтээж байгаа дагаврын тохиолдох байрыг тодорхойлохын тулд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбарын “Хуулийн хэлний үгийн сан, хэл зүйн судалгаа” сэдэвт төсөлт ажлын хүрээнд Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа 449 хуулийн нэр томьёо, тодорхойлолт бүхий анхдагч материалын санг судалгааны эх хэрэглэгдэхүүнээр ашиглаж, стандартуудыг нэг цаг үед авч үзэж байгаа нь хам цаг (synchrony)-ийн судалгаа болж байна. Энэхүү хуулийн нэр томьёоны цахим санд суурилсан судалгааны үндсэн арга нь үгсийг материалын санд бүртгэх бөгөөд хэл зүй-үгийн сангийн нарийн задлалтаар тэмдэгжүүлэн бүрдүүлбэрийн задаргаа хийх, хам бичвэрийн аргаар хам сэдвээс үгсийг ялгав. Улмаар үгсийн сангийн хэрэглээний чанарыг үнэлэх, үгийн бүтэц, хэрэглэн дэх давтамжийг тогтооход Японы Васеда Их Сургуулийн Шинжлэх ухаан, инженерчлэлийн факультетын профессор Лоренс Антоны боловсруулсан AntConc (Антон, 2014) болон EXCEL программын хэрэгслүүдийг ашиглав. Мөн нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, тайлбарлан бичих зэрэг олон аргыг ашиглав.

3. Судалгааны үндсэн хэсэг

Бид хуулийн нэр томьёоны нэгдсэн сангаас өөрсдийн эх хэрэглэгдэхүүн болох дан нэр томьёог түүвэрлэн авч, хэл зүй-үгийн сангийн нарийн задлалтаар тэмдэгжүүлэн бүрдүүлбэрийн задаргаа хийх, хам бичвэрийн аргаар хам сэдвээс үгсийг ялгах, улмаар үгсийн сангийн хэрэглээний чанарыг үнэлэх, үгийн бүтэц, хэрэглэн дэх давтамжийг тогтоон, улмаар дан нэр томьёог бүтээж байгаа дагаврын гүйцэтгэх үүрэг, давтамж, бүтээлчээр хэрэглэгдэж байгаа эсэх, илэрхийлж байгаа утгын оновчтой болсон эсэхийг тодруулах зорилгынхоо хүрээнд уг цахим сандаа дараах алхам дарааллаар ажиглалт хийв. Үүнд:

1. Төрөлжүүлэн ангилах;
2. Төрөлжүүлсэн нэр томьёоныхоо бүтцийг тодорхойлж, үгийн аймгаар ангилах
3. Дан бүтэцтэй нэр томьёоны давтамжийг тодорхойлох
4. Дан бүтэцтэй нэр томьёонд ажиглалт хийх
5. Зарим нэр томьёог дахин боловсруулах, оновчтой болгох талаар өөрсдийн саналыг дэвшүүлж, нэгтгэн дүгнэх зэрэг болно.

3.1 Төрөлжүүлэн ангилах

Цахим санг байгуулж, боловсруулахад хамгийн эхэнд шаардагддаг зүйл бол өгөгдлүүдийг төрөлжүүлж, ангилах явдал юм. Учир нь судалгааны үр дүнг тооцоололд суурильж гаргахад жигдэлсэн өгөгдөл дээр ажиллах шаардлагатай байдаг. Ийм бид

1. DataSource хуудсанд аливаа өөрчлөлт ороогүй эх сурвалж өгөгдөл дээр ажиллаж, стандарт тус бүр дотор ижил утга, тодорхойлолт бүхий давхардсан нэр томьёо байгаа эсэхийг хянаж, жигдлэв.
2. Зөв бичих дүрмийн алдаатай бичсэн нэр томьёо байгаа эсэхийг хянаж, жигдлэв ("Болорсофт", 2022).
3. Нэр томьёо, харьяалагдах салбар, нэр томьёоны тодорхойлолт тус бүрийг агуулсан баганыг 'Excel Table' болгон хөрвүүлж тус бүрд 'st_' гэсэн утвартай нэр өгөв.
4. DataCleaning хуудсанд өгөгдлүүдийг дараах алхмын дагуу цэвэрлэв.
=TRIM(CLEAN(LOWER(cl_1[Class 1]))), '/'-

Үл үзэгдэх тэмдэгтүүдийг устгав. Line Break, Grouping гэх мэт тэмдэгтийг (=clean) устгав.

'-' Эхлэл ба төгсгөлийн хоосон зайг устгаж (=trim), тооцоолол гаргахад бэлэн болгов.

Бид 449 хуулийн үгийн сангаар цахим санг байгуулав. Улмаар тус цахим сандаа түшиглэж, 1399 нэр томьёог түүвэрлэн, хуулийн нэр томьёоны дэд цахим санг бүрдүүлэв.

Хүснэгт №1. Хуулийн нэр томьёог төрөлжүүлж ангилсан байдал

	A	B	C	D
	НЭР ТОМЬЁО	ҮГИЙН ТОО	ТОДОРХОЙЛОЛТ	ЭХ СУРВАЛЖ
1177	АГААР	1	монгол улсын нутаг дэвсгэрийн хийн бүрхэвч барилга байгууламжийн ажил, тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгын ажил, түүнчлэн тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бараа нийлүүлэлт	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он, 3.1.5
1178	АЖИЛ	1	ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа иргэн	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль, 2000 он, 4.1.14
1179	АЖИЛТАН	1	даатгагчийн төлбөрийн чадварын түвшин, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор учирч болзошгүй эрсдлийг урьдчилан үнэлж, эдийн засаг, математикийн тооцоо, судалгааны үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг этгээд	Хөдөлмөрийн тухай хууль, 1999 он, 3.1.2
1180	АКТУАРЧ	1	хууль болон гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр төлөхөөр тогтоосон анз	Даатгалын тухай хууль, 2004 он, 4.1.8
1181	АЛДАНГИ	1	монгол улсын нутаг дэвсгэрт байнга буюу түр нутагшсан хөхтөн, шувуу, мөдхөгч, хоёр нутагтан, загас, хавч хэлбэртэн, шавьж, зөөлөн биетэн, эгэл биетэн	Иргэний хууль, 2002 он, 232.6
1182	АМЬТАН	1		Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он, 3.1.4

Боловсруулахад бэлэн болсон материалын сангаа дэс дугаар, нэр томьёо, орчуулга, үгийн аймгийн ангилал, давтамж, бүтцийн ангилал, дагаврын утга, үгийн утга, тодорхойлолт, нэмэлт тайлбар гэсэн хэмжигдлээр ялгаж, үндсэн 10 зүйлээр онцлогийн тасалбар хадав.

Хүснэгт №2. Хуулийн нэр томьёонд онцлогийн тасалбар хадсан байдал

	A	C	E	F	G	H	J	K
1	НЭР ТОМЬЁО	Үгийн аймгийн ангилал	Давтамж	Бүтцийн ангилал	Бодит утга/ хийсвэр утгатай эсэх	Дагаврын утга	Тодорхойлолт	Холбогдох хуулийн нэр
2	АГААР	ж.нэр	73	үүсмэл бус	үүсмэл бус	0	Монгол Улсын нутаг дэвсгэрийн хийн бүрхэвч	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он, 3.1.5
3	АЖИЛ	ж.нэр	1974	үүсмэл бус	үүсмэл бус	0	Барилга байгууламжийн ажил, тоног төхөөрөмжийн утсралт, суурилуулалт, туршилт тохируулгын ажил, түүнчлэн тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бараа нийлүүлэлт	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль, 2000 он, 4.1.14
4	АЖИЛТАН	ж.нэр	704	үүсмэл	бодит утга	Хам олны утгатай нэр томьёо бүтээх дагавар	Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа иргэн	Хөдөлмөрийн тухай хууль, 1999 он, 3.1.2
	АЖИЛТАН	ж.нэр		үүсмэл	бодит утга	Хам олны утгатай нэр томьёо бүтээх дагавар	Даатгагчийн төлбөрийн чадварын түвшин, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор учирч болзошгүй эрсдлийг урьдчилан үнэлж, эдийн засаг, математикийн	Даатгалын тухай хууль, 2004 он, 4.1.8

Мөн тухайн судалгааны ажлын зорилготой уялдуулан, хуулийн нэр томьёоны дан ба нийлмэл бүтэц, монгол ба гадаад үг, үгийн дэлгэрэнгүй бүтэц гэсэн нэмэлт онцлогийн тасалбарыг хадаж, төрөлжүүлэн ангилахад бэлэн болгов. Ийнхүү материалын санд боловсруулалт хийж, хөмрөг хэл шинжлэлийн судалгаанд түгээмэл мөрддөг “Баталгаат, тэмдэглэгээт сан”-аа байгуулснаар дараагийн алхам болох хуулийн нэр томьёоны бүтцийг тогтоох үндсэн нөхцөлийг бүрдүүлэв.

3.2 Төрөлжүүлсэн нэр томьёоныхоо бүтцийг тодорхойлж, үгийн аймгаар ангилах

Бид эхний ээлжид материалын сандаа томьёо ашиглаж, дан болон нийлмэл бүтэцтэй нэр томьёог тодорхойлсны суурь дээр МУИС-ийн Хэрэглээний Шинжлэх Ухааны Инженерчлэлийн Сургуулийн харьяа судалгааны лабораторийн боловсруулсан “Монгол хэл боловсруулалтын үзүүлэн хуудас (лаборатори, 2016)”-ыг гараар тэмдэглэгээ хийх аргатай хослуулж ашиглав (Хүснэгт №2). Учир нь материалын сан дахь дан бүтэцтэй нэр томьёоны үгийн аймгийн автомат болон нэрлэсэн нэгжийн тэмдэглэгээний танилтын хувь хангалтгүй байсан учраас үгийн бүтэц дэх дагаврын байрлалыг нэмэлтээр гараар тэмдэглэв.

Хүснэгт №3. Стандартчилсан нэр томьёоны үгийн бүтэц ба үгийн аймгийн тооцоолол

№	Үндэс	Үгийн аймаг	Нэрлэсэн нэгж	Үгийн бүтцээр задалсан байдал
1	АЖИЛТАН	Жинхэнэ нэр	N	Ажил+тан
2	АЛДАНГИ	Жинхэнэ нэр	N	Алд+нги
3	БООДОЛ	Жинхэнэ нэр	N	Боо+дол
4	АЧАА	Жинхэнэ нэр	N	Ач+аа

5	АШИГЛАЛТ	Жинхэнэ нэр	N	Ашиг+л+лт
6	ЗӨВЛӨХ	Үйл үг	V	Зөв+л+х
7	НИСЭХ	Үйл үг	V	Нис+х
8	ЭМЧЛЭХ	Үйл үг	V	Эмч+л+х
9	ХАЛХАВЧЛАХ	Үйл үг	V	Халх+вч+л+х
10	СУВИЛАХ	Үйл үг	V	Сувил+х

Монгол хэл нь залгамал бүтэцтэй бөгөөд язгуурын араас дагавар залгаж үндэс үүсгэх, нөхцөл залгаж үг хувилгадаг онцлогтой. Энэ шинжийг шинэ үг бүтээх боломжийн талаас харахад нугалмал болон тусгайлаг хэв шинжийн хэлнээс хязгаарлагдмал байдалтай. Учир нь, монгол хэлний үгийн язгуурын өмнө угтвар болон угтвар үгийг залган шинэ үг үүсгэдэггүйтэй холбоотой. Монгол хэлний бүтцийн онцлогоос хамаарч үг бүтээх түүнчлэн шинэ нэр томъёо бүтээх үндсэн арга нь язгуурт дагавар залгах нийлэг арга, хоёр өөр язгуур нийлж шинэ үг бүтээх задлаг арга гэдгийг судлаачид нэгэнт тогтоожээ (Т.Батбямба, 2023).

3.3 Төрөлжүүлсэн нэр томъёоныхоо бүтцийг тодорхойлж, үгийн аймгаар ангилах

Түүвэрлэн авсан 1399 хуулийн нэр томъёог бүтэх аргаар ангилж үзэхэд, дан бүтэцтэй нэр томъёо 219, нийлмэл бүтэцтэй нэр томъёо 1180 байна. Тус судалгааны ажлын зорилгын хүрээнд дан бүтэцтэй нэр томъёогоо монгол хэлний үг бүтэх аргаар ангилж үзвэл, үүсмэл нэр томъёо 140, үүсмэл биш нэр томъёо 79 бүртгэгдэв. Үүсмэл буюу дагаврын аргаар бүтсэн нэр томъёог судлаач Г.Гэрэлмаагийн нэр томъёо бүтэх аргыг тодорхойлсон ангилалд (Г.Гэрэлмаа, 2020) тулгуурлан авч үзвэл доорх мэт байна. Тухайлбал:

Үүсмэл нэр томъёог бүтээж буй дагаврууд:

Бодит утгатай дагавар: Биет хийгээд бодит юм үзэгдлийн илтгэх утгыг бүтээдэг дагавруудыг энд багтаан үздэг байна. Дан бүтэцтэй 88 нэр томъёо бодит утгатай *-ч*, *-гч*, *-чин*, *-тан^д*, гэх мэт дагавраар бүтэж, 62.85 хувийг эзэлжээ.

1. Ажил мэргэжил заасан утгатай нэр томъёо бүтээх дагавар: Нэр язгуурт *-ч*, *-чин*, *-гч* дагаврыг залгаж, ажил мэргэжил, мэргэшил чадварыг заан нэрлэсэн нэр томъёо бүтээхэд

гэрлэгчид = гэр+л+гч+д

(Гэрлэлтээр холбогдсон харилцан тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээх нөхөр, эхнэр. Гэр бүлийн тухай хууль, 1999 он, 3.1.3)

хамжигч = хам+ж+гч

(Зааж зөвлөх, зэвсэг, хэрэгсэл өгөх, учрах саадыг арилгах, унаа, орон байраар хангах зэргээр гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлсэн, түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн этгээд болон гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг,

хэрэгсэл, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг нуун далдлах, зарж борлуулах, гэмт хэргийн ул мөрийг баллахаар урьдчилан амалсан¹ этгээд. Эрүүгийн хууль, 2002 он, 35.6) (ТОГТООЛ, 2003)

ноёрхогч = ноён+рх+гч

(Давамгайл байдлаа хууль бусаар ашиглах, өрсөлдөгчөө зах зээлд ороход саад учруулах, өрсөлдөөнийг болон хэрэглэгчийг хясан боогдуулахыг ноёрхох үйл ажиллагаанд тооцож, ийм төрлийн үйл ажиллагаа явуулсан этгээд. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль, 2000 он, 5.2)

мэдүүлэгч = мэд+үүл+гч

(Гаалийн хилээр нэвтрэх бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагад мэдүүлсэн, эсхүл мэдүүлж байгаа аливаа хүн. Эрүүгийн хууль, 2002 он, 3.1.8)

тамирчин = тамир+чин

(Спортлоо системтэй хичээллэж, тэмцээнд оролцдог этгээд. Биеийн тамир, спортын тухай хууль, 2003 он, 3.1.5)

актуарч = актуар+ч

(Даатгагчийн төлбөрийн чадварын түвшин, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор учирч болзошгүй эрсдлийг² урьдчилан үнэлж, эдийн засаг, математикийн тооцоо, судалгааны үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг этгээд. Даатгалын тухай хууль, 2004 он, 4.1.8) (ХУУЛЬ, 2004)

2. Хам олны утгатай нэр томьёо бүтээх дагавар: Ганц тоот үндсэнд -тан⁴, -ынх², -ийнхан³ зэрэг дагаврыг залгаж олны утга илтгэсэн байна. - 4

амьтан = амь+тан

(Монгол улсын нутаг дэвсгэрт байнга буюу түр нутагшсан хөхтөн, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан, загас, хавч хэлбэртэн, шавьж³, зөөлөн биетэн, эгэл биетэн. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он, 3.1.4) (БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ, 1995)

ажилтан = ажил+тан

- *(ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа иргэн. Хөдөлмөрийн тухай хууль, 1999 он, 3.1.2)*
- *(биеийн тамир, спортын байгууллагад ажиллаж байгаа болон биеийн тамир, спортын үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд. Биеийн тамир спортын тухай хууль, 2003 он, 3.1.9)*

Хийсвэр утгатай дагавар: Үг бүтээх үндэс нь идэвхтэй болон идэвхгүй, нэр

¹ Амласан гэж бичих нь зүйтэй.

<https://toli.gov.mn/search?q=%D0%B0%D0%BC%D0%BB%D0%B0%D1%81%D0%B0%D0%BD&t=%D0%A2%D0%9E%D0%9B%D0%AC>

² Эрсдэлийг гэж бичих нь зүйтэй.

<https://toli.gov.mn/search?q=%D0%AD%D1%80%D1%81%D0%B4%D1%8D%D0%BB&t=%D0%A2%D0%9E%D0%9B%D0%AC>

³ Шавьж гэж бичих нь зүйтэй. <https://toli.gov.mn/w/mkmTkOJW8eLtPkUp>

болон үйлийн аль нэг байхаас үл хамааран аливаа юмс үзэгдлийн хийсвэр төлөв болох гадаад болон дотоод шинж чанар заасан утгатай нэр томъёо бүтээж буй *-раг⁴, -т, -тай³, -лаг, -мал⁴, -нг⁴, -мхай, -мхий, -мтгой, -хай⁴, -нгуй* (Г.Гэрэлмаа, 2020) зэрэг дагаврыг хийсвэр утгатай дагавар хэмээн үзээд тус ангилалд оруулав. Бидний бүртгэлээр дан бүтэцтэй 52 нэр томъёо бодит утгатай *-лт, -мж, -л, -ж* гэх мэт дагавраар бүтэж, дан бүтэцтэй хуулийн нэр томъёоны 37.14 хувийг эзэлжээ.

1. Үйлийн үр дүн, болц заасан утгатай нэр томъёо бүтээх дагавар – 51 жагсаал = жагс+аа+л

(иргэд хот суурингийн⁴ гудамж талбайгаар зохион байгуулалттайгаар жагсан явж, монгол улсын иргэдээс улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа илэрхийлж байгаа. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль, 1994 он, 3.2) (ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ / Шинэчилсэн найруулга/, 2025)

дүгнэлт = дүн+нэ+лт

(Аливаа үйл ажиллагаа, ажил хэрэг, бодит байдлын явц, үр дүнг тодорхойлсон баримт бичиг. MNS 5140 : 2002)

удирдамж = удирд+мж

(Тодорхой ажил хэрэг гүйцэтгэхэд удирдлага болгох зүйлийг тодорхойлсон баримт бичиг. MNS 5140 : 2002)

хамжигч = хам+ж+гч

(Зааж зөвлөх, зэвсэг, хэрэгсэл өгөх, учрах саадыг арилгах, унаа, орон байраар хангах зэргээр гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлсэн, түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн этгээд болон гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг нуун далдах, зарж борлуулах, гэмт хэргийн ул мөрийг баллахаар урьдчилан амалсан⁵ этгээд. Эрүүгийн хууль, 2002 он, 35.6) (ТОГТООЛ, 2003)

2. Шинж чанар заасан нэр томъёо бүтээх дагавар:– 1

алданги = алд+нги

(хууль болон гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр төлөхөөр тогтоосон анз. Иргэний хууль, 2002 он, 232.6)

Дээрхээс гадна тус санд дагаврын аргаар бүтсэн үгс цөөнгүй илэрсэн. Жишээ нь:

- нэрээс нэр үг бүтээх дагавар залгаж бүтсэн нэр томъёо: *хувьцаа*,
- нэрээс үйл үг бүтээх дагавар залгаж бүтсэн нэр томъёо: *зурагжуулах, цагаачлах, эмчлэх*,

⁴ Суурины гэж бичих нь зүйтэй. <https://d.parliament.mn/tusul/40e9e98f-543e-4580-9b00-195d0f263ec0>

⁵ Амласан гэж бичих нь зүйтэй.

<https://toli.gov.mn/search?q=>

[%D0%B0%D0%BC%D0%BB%D0%B0%D1%81%D0%B0%D0%BD&t=](https://toli.gov.mn/search?q=%D0%B0%D0%BC%D0%BB%D0%B0%D1%81%D0%B0%D0%BD&t=)

[%D0%A2%D0%9E%D0%9B%D0%AC](https://toli.gov.mn/search?q=%D0%A2%D0%9E%D0%9B%D0%AC)

- тэмдэг нэрээс үйл үг бүтээх дагавар залгаж бүтсэн нэр томьёо: *зөвлөх*,
- үйлээс нэр үг бүтээх дагавар залгаж бүтсэн нэр томьёо: *заавар, өргөдөл, шүүх, хориоо, захирамж*,
- хэт олон дагавар залгаж, нэр томьёо бүтсэн нэр томьёо: *халхавчлах, мэргэшил, нөхөрлөл, итгэмжлэл, гэрчилгээ, байгууллага* гэх мэт.

Үгийн аймгийн хувьд *сууц, сүлжээ, тайлан* зэрэг 210 жинхэнэ нэр, *зурагжуулах, сувилах, цагаачлах* зэрэг 8 үйл үг, эрлийз гэсэн 1 тэмдэг нэр илэрсэн.

Үгийн сангийн бүрэлдүүлбэрийн хувьд уугуул үгээс бүтсэн нэр томьёо 185 буюу 84.7 хувийг, харь үгээс бүтсэн нэр томьёо 34 буюу 15.53 хувийг тус тус эзэлжээ.

Харь гаралтай нэр томьёоны дунд *гадаад үг + дагавар* гэсэн бүтэцтэй дан нэр томьёо цөөнгүй илэрсэн. Жишээ нь:

- арбитирчб = арбитир + ч
- актуарч = актуар + ч
- нотариатч = нотариат + ч

Мөн түүнчлэн *гадаад үг + монгол үг* гэсэн бүтэцтэй нэр томьёо илэрсэн. Жишээ нь:

- биобэлдмэл = био + бэлдмэл

Хууль зүйн нэр томьёоны санд иргэдийн өдөр тутмын амьдралдаа хэрэглэдэг буюу агаар, ажил, амьтан, бараа, бүтээгдэхүүн, валют, банк, донор зэрэг ерийн үгсээс гадна докторант, биобэлдмэл, фармакопей (*pharmacopeia*), дархлаажуулалт, зарлиг, захирамж, тушаал, тогтоол, гэх мэт шинжлэх ухааны нэр томьёо ч олон байдаг. Тэдгээр нэр томьёонуудын зарим нь харь гаралтай учраас дүйцэлд тулгуурлан орчуулах аргыг хэрэглэхээс гадна, дүйцэлгүй нэр томьёог буулгахдаа галигчилж⁷ эсвэл үсэгчлэн хөрвүүлж⁸ буулгасан (Н.Мөнхцэцэг, 2020) байна. Жишээ нь:

Галигчлан хөрвүүлэх аргаар буулгасан нэр томьёо:

- *technology – технологи*
- *journal- журнал*
- *know-how - ноу-хау*

Үсэгчлэн хөрвүүлэх аргаар буулгасан нэр томьёо:

- *terrorism – терроризм*
- *grant – грант*
- *erotic – эротик гэх мэт.*

Харин тус санд хуулбарлан болон утгачлан орчуулсан дан бүтэцтэй харь гаралтай нэр томьёо илэрсэнгүй.


⁶ Арбитрч гэж бичих нь зүйтэй.

⁷ Энэ нь өөрийн хэлний үсгийг ашиглан, гадаад үгийн авиаг тэмдэглэдэг авиа зүйн арга юм.

⁸ Гадаад нэр томьёог үсэглэх арга гэдэг нь гадаад үгийн үсэг бүрийг өөрийн хэлний үсгээр орлуулан бичих хэлбэр зүйн арга юм.

Бид хуулийн нэр томъёоны цахим сангийнхаа 1.696.931 үгийн давтамжийг Antconc (Антон, 2014) программ ашиглан тооцож үзэхэд дараахчдугуй тоогоор

Зураг №1. Давтамжийн тооцоолох явц



Хүснэгт №4. Давтамжийн тооцоолол

№	Нэр томьёо	Давтамж	Бүтцийн ангилал
1	байгууллага	7500	үүсмэл
2	газар	3991	үүсмэл бус
3	шийдвэр	2207	үүсмэл
4	иргэн	2139	үүсмэл бус

5	мэдээлэл	1997	үүсмэл
6	ажил	1974	үүсмэл бус
7	шүүх	1821	үүсмэл
8	журам	1548	үүсмэл бус
9	сан	1204	үүсмэл бус
10	дүгнэлт	987	үүсмэл
НИЙТ		24381 - 1.43%	50:50

Тооцооллоос үзвэл, “байгууллага”⁹ гэсэн нэр томьёо хамгийн олон удаа буюу 7500 удаа, “нэрвэгдэгсэд”¹⁰ гэсэн нэр томьёо хамгийн цөөн буюу нэг удаа давтагджээ.

3. Судалгааны үр дүн, хэлэлцүүлэг

- Бидний бүрдүүлсэн давхардсан тоогоор 1.696.931 үгтэй (давхардаагүй тоогоор 90.299 нэгж үгтэй) 449 хуулийн үгийн санд илэрсэн 1399 нэр томьёоны 219 буюу 15.66 хувийг дан бүтэцтэй нэр томьёо, 1180 буюу 84.34 хувийг нийлмэл бүтэцтэй нэр томьёо эзэлсэн байна.
- “Байгууллага”¹¹ гэсэн нэр томьёо хамгийн олон удаа буюу 7500 удаа, “нэрвэгдэгсэд”¹² гэсэн нэр томьёо хамгийн цөөн буюу нэг удаа давтагджээ.
- Дан нэр томьёоны 140 буюу 63.92 хувийг үүсмэл нэр томьёо, 79 буюу 36.08 хувийг үүсмэл биш нэр томьёо эзэлсэн байна.
- Үгийн аймгийн хувьд 210 буюу 95.89 хувийг жинхэнэ нэр, 8 буюу 3.65 хувийг үйл үг, 1 буюу 0.45 хувийг тэмдэг нэр эзэлсэн байна.
- Үүсмэл нэр томьёоны ихэнх нь *-ч, -гч, -чин, -лт, -мж, -л гэсэн дагавраар бүтсэн байна*. Дагаврын аргаар бүтсэн дан бүтэцтэй нэр томьёоны тооцоо бүртгэлээс үзэхэд, бодит утгатай дагавар залгаж бүтсэн нэр томьёо нь хийсвэр утгатай нэр томьёоноос харьцангуй олон илэрсэн байна. Жишээ нь: *талууд*¹³, *эрдэнэс*¹⁴.
- Үгийн сангийн бүрэлдүүлбэрийн хувьд уугуул үгээс бүтсэн нэр томьёо 185

⁹ Тодорхойлолт: тодорхой чиг үүрэг, бүрэн эрх бүхий хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн этгээд. Байгууллагын нууцын тухай хууль, 1995 он, 3.1.1

¹⁰ Тодорхойлолт: Гамшгийн улмаас амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохирогчид. Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 он, 4.1.13

¹¹ Тодорхойлолт: тодорхой чиг үүрэг, бүрэн эрх бүхий хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн этгээд. Байгууллагын нууцын тухай хууль, 1995 он, 3.1.1

¹² Тодорхойлолт: Гамшгийн улмаас амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохирогчид. Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 он, 4.1.13

¹³ Шүүх хуралдаанд тэгш эрхтэйгээр мэтгэлцээнд оролцож, яллах, өмгөөлөх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд. Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002, 5.1.6

¹⁴ түүхий эд, хайлш, химийн нэгдэл, бүтээгдэхүүн, түүх, соёлын дурсгалт зүйл зэрэг ямар ч байдалд байгаа үнэт металл, эрдэнийн чулуу. Эрдэнэсийн сангийн тухай хууль, 1994 он, 3.1

буюу 84.7 хувийг, харь үгээс бүтсэн нэр томьёо 34 буюу 15.53 хувийг тус тус эзэлсэн бөгөөд тэдгээр харь гаралтай үгсийг монгол хэлнээ орчуулан хэрэглэхдээ хуулбарлан болон утгачлан орчуулаагүй байна. Харин үсэгчлэн хөрвүүлэх, галигчилж хөрвүүлэх аргыг ашигласан байна.

- Хуучин үгийг сэргээж хэрэглэсэн жишээ нэг илэрсэн. Жишээ нь: *анз*¹⁵.

Хуулийн санд зөв бичих дүрмийн алдаатай бичсэн үгс цөөнгүй илэрсэн. Жишээ нь: *амалсан - амласан, шавж – шавжс, суурингийн – суурины, эрсдлийг – эрсдлийг* гэх мэт.

4. Дүгнэлт

Бид энэхүү өгүүллийн хүрээнд 449 хуулийн 1,696,931 үгтэй судалгааны эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан, дан буюу энгийн нэр томьёоны бүтцийн судалгааг хийлээ.

- Тус хуулийн санд дан буюу энгийн нэр томьёо (15.66%) нь нийлмэл нэр томьёо (84.34%)-оос 5.2 дахин бага хувийг эзэлжээ. Дан үг бага байна гэдэг нь дүйцлийн тухай асуудалтай холбоотой учраас нэр томьёогоор илэрч байгаа ухагдахууныг бүтээхдээ шинэ үг хэллэг зохиох, хуучин болон уламжлалт үгийг сэргээн хэрэглэх зэрэг олон бүтээлч аргыг ашиглах, цаашлаад хэлний хэмнэлтийг зарчмыг баримтлах шаардлагатайг харуулж байна.
- Үгийн аймгийн хувьд 95.89 хувийг жинхэнэ нэр, 3,65 хувийг үйл үг, 0.45 хувийг тэмдэг нэрээр илэрсэн нэр томьёо эзэлж байгаа нь ер нь нэр томьёо нэр болон үйл үгээр илэрдгийг харуулж байна.
- Бусад сантай харьцуулахад гэсэн олон тооны дагавраар бүтсэн хуулийн нэр томьёо илэрсэн нь тус сангийн онцлогийг харуулж байна.
- Бүтцийн хувьд 140 буюу 63.92 хувь үүсмэл нэр томьёо илэрчээ. Нэр томьёо бүтээж байгаа бодит утгатай дагавар (25.57%) нь хийсвэр утгатай болон бусад дагавруудтай харьцуулахад харьцангуй их хувийг эзэлж байна. Үг бүтээх дагавраар бүтээсэн нэр томьёонууд нь хэвшин тогтсон байгаа нь ажиглагдаж байна.
- Харь үгийн хувьд олон улсын үгийг хөрвүүлэхдээ нь жигд бус байна. Энэ нь англи үг, нэр томьёог галиглах, үсэгчлэх дүрмийг стандартжуулахын чухлыг илэрхийлж байна. Гадаад нэр томьёог зөв орчуулж, оноохын тухайд *тариф – үнэ өртөг, журнал – бүртгэлийн дэвтэр* хэмээсэн монгол нэр томьёогоо хэрэглэж занших шаардлагатай байна.

5. Ном зүй

Батбямба, Т. (2023). Стандарт дахь нэр томьёоны бүтцэд хийсэн тоон шинжилгээ. *Хэрэглээний хэл шинжлэл*, VIII (23):16-25. [Batbyamba, T. *Standart dakhi ner*

¹⁵ Хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй тал хууль болон гэрээнд зааснаар нөгөө талдаа төлөх ёстой мөнгөн төлбөр. Иргэний хууль, 2002 он, 232.1

tomiyony büttseд khiisen тоон шинжилгээ [Quantitative Analysis on Terminology Structure in Terminology Standarts, *Heregleenii hel шинжлэл*, 2023, VIII(23): 16-25]

Батбямба, Т. (2024). Стандартчилсан нэр томъёоны сан дахь дан бүтэцтэй нэр томъёоны дагаврын байр, харьцаа. *Хэрэглээний хэл шинжлэл*, IX (24):24-39. [Batbyamba, T. *Standartchilsan ner tomiony san dakhi dan бүтэтstei ner tomiony dagavryn bair, kharitsaa*. [The Position and Relation of Single Terms in the Standartized Term Corpus, *Heregleenii hel шинжлэл*, 2024, IX(24): 24-39]

Гэрэлмаа, Г. (2020). *Монгол хэлний нэр томъёо бүтэх нийлэг болон задлаг хэв шинж*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Gerelmaa, G. *Mongol khelnii үг бүтөkh zadlag болон нийлэг khев шинж* [Analytic and Synthetic Methods of Creating Terms in Mongolian] Ulaanbaatar: Soyombo printing. 2020]

Мөнхцэцэг, Н. (2020). *Нэр томъёоны орчуулга судлал*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Münkhtsetseg, N. *Ner tomiony orchuulga судлал* [Translation-Oriented Terminology]. Ulaanbaatar: Soyombo printing. 2020]

Нарангэрэл, Н., Болд, Л., Өнөрбаян, Ц., Базаррагчаа, М., Гантогтох, Г., Баянсан, Ж., Санжаа, Ж., Самбуудорж, О., Заяабаатар, Д., Бямбацэрэн, Г., Жумдаан, Л., Баярсайхан, М., Пүрэвжав, Э., Түвшинтөгс, Б., Элбэгзаяа, Б., Энхтуяа, Л., Даваасүрэн, Т. (2018). *Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь*, Улаанбаатар. [Narangerel, N., Bold, L., Ünürbayan, Ts., Bazarragchaa, M., Gantogtokh, G., Bayansan, J., Sanjaa, J., Sambuudorj, O., Zayabaatar, D., Byambatseren, G., Jumdaan, L., Bayarsaikhan, M., Pürevjav, E., Tüvshintugs, B., Elbegzaya, B., Enkhtuya, L., Davaasüren, T. *Mongol khelnii zöv bichih дүрmiin juramlasan toli* [Orthographic Dictionary of Mongolian Language]. Ulaanbaatar. 2018]

Шагдарсүрэн, Ц. (2009). Нэр үгийн -лт дагавар болон үйл үгийн -х бүхий хэлбэрийн хэрэглээ хийгээд мөн чанар. Монгол Улсын Их Сургууль, *Монгол хэл соёлын сургууль, эрдэм шинжилгээний бичиг*, Боть. XXX(318), 139-145. [Shagdarsüren, Ts. *Ner үгийн -lt болон үйл үгийн -kh бүkhii niit khereglee мөн чанар* [Characteristic and usage of verb form “-х”, affix “-лт” of noun, *Journal of Mongolian Studies*, Tom. XXX(318), 139-145]

Цахим холбоос:

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=11915>

<https://legalinfo.mn/mn/detail/232>

www.spellcheck.mn

<https://d.parliament.mn/tusul/40e9e98f-543e-4580-9b00-195d0f263ec0>

<https://www.laurenceanthony.net/software/antconc/>.

<http://172.104.34.197/nlp-web-demo/>

6. Талархал

Бид тус өгүүллээ *ШУА-ийн ХЗХ-ийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбарын “Хуулийн хэлний үгийн сан, хэл зүйн судалгаа”* сэдэвт төсөлт ажлын хүрээнд бичсэн бөгөөд стандартын нэр томъёоны цахим сан бүрдүүлэхэд хамтран ажилласан Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын алба болон энэхүү судалгааг хийхэд үнэтэй заавар, зөвлөгөө өгч, онолын ном бүтээлээр хангаж дэмжин ажилласан, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбарын хамт олонд талархсан сэтгэлээ илэрхийлье.

Хавсралт 1

ХАМГИЙН ЦӨӨН ДАВТАМЖТАЙ ХУУЛИЙН ДАН БҮТЭЦТЭЙ НЭР ТОМЬЁО

№	НЭР ТОМЬЁО	Давтамж
1	нэрвэгдэгсэд	1
2	докторант	2
3	зурагжуулах	2
4	магистрант	2
5	тодруулалт	2
6	хамжигч	2
7	иргэн	3
8	үйлчлэгч	3
9	цагаач	3
10	дайсан	4
11	журнал	4
12	компани	4
13	лиценз	4
14	мэдүүлэг	4
15	мэдүүлэгч	4
16	ноёрхогч	4
17	нэхэмжлэгч	4
18	өмгөөлөгч	4
19	реципиент	4
20	үр	4
21	хариуцагч	4
22	хөдөлгөөн	4
23	хөрс	4
24	эрлийз	4
25	арбитрч	5

26	зурмаг	5
27	ноу-хау	5
28	өргөдөл	5
29	өрсөлдөгч	5
30	солиорол	5
31	терроризм	5
32	хөтөлбөр	5
33	хэрэглэгч	5
34	шарлага	5
35	актуарч	6
36	аудитор	6
37	илгээлт	6
38	тогтоол	6
39	шийдвэр	6
40	төлбөр	7
41	шүүлт	7
42	эрдэнэс	7
43	фармакопей	8
44	шүүх	8
45	грант	9
46	цуврал	9
47	эмчлэх	9
48	ажилтан	10
49	гэрлэгчид	10
50	гэрээ	10
51	төсөл	10
52	удирдамж	10
53	халхавчлах	10